



“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

***Зуух №6 их засвар***

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

***ДЦСЗ/20240101002***

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	7
1. Тендерийн цар хүрээ .....	7
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	7
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	7
4. Худалдан авах ажиллагааны цахим систем.....	7
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.....	7
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага.....	7
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага .....	8
Б.АГУУЛГА.....	8
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	8
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	8
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	9
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах.....	9
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ.....	9
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	9
13. Тендерийн иж бүрдэл .....	9
14. Тендерийн жишиг маягтууд .....	10
15. Хувилбарт санал.....	10
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг .....	10
17. Чадавхын болон туршлагын шаардлага.....	11
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	11
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	11
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	12
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	12
22. Тендерийн валют .....	13
23. Тендер хүчинтэй байх хугацаа .....	13
24. Тендерийн баталгаа .....	13
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ .....	13
25. Тендер баталгаажуулах, илгээх .....	13
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	14
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ .....	14
27. Тендерийн талаар тодруулга авах.....	14
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	14
29. Тендерийг үнэлэх.....	14
30. Арифметик алдааг залруулах .....	14
31. Давуу эрх олгох.....	14
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	14
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	15
34. Тендерийг эрэмбэлэх .....	15
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах.....	15
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ .....	15

36.	Мэдэгдэл хүргүүлэх .....	15
37.	Гүйцэтгэлийн баталгаа .....	15
38.	Урьдчилгаа төлбөр .....	15
39.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах .....	16

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**
- 6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
- 6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

## **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б. АГУУЛГА**

## **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

## **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

#### **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1.Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3.ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

#### **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

### **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

#### **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

#### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1.Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн

ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн

гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

## **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

## **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

## **19. Техникийн чадавх болон**

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн



**туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

**20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1.Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4.ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5.ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6.Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохирүүлга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах

хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## 22. Тендерийн валют

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## 23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## 24. Тендерийн баталгаа

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

## 25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2.ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын

агуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2.Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

**Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

**27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1.Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

**29. Тендерийг үнэлэх**

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

**30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

**31. Давуу эрх олгох**

31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

**32. Үнэлгээнд харгалзах**

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан

- шалгуур үзүүлэлт** үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

### **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр**
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан

захиалагчид ирүүлнэ.

38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

**39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>“Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц” ТӨХК</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>Зуух №6 их засвар</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>ДЦСЗ/20240101002</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багцгүй</i>
<b>ТШЗ 1.3</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>2,168,626,500 (хоёр тэрбум нэг зуун жаран найман сая зургаан зуун хорин зургаан мянга таван зуун) төгрөг</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.1</b>	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <b>Турбины засварын инженер Б.Бизъяа</b> Хаяг: <b>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн байр, 215 тоот.</b> Утасны дугаар: <b>11-344111</b> Цахим шуудангийн хаяг: <b>ps3@tes3.energy.gov.mn</b>
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.1</b>	Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл.</b>
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
<b>ТШЗ 16.1.2</b>	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b> - ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх талаар албан бичгээр мэдэгдэх - Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой баримт бичгийг Монгол улсын, эсхүл үүсэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан цахимд байршуулах - Түншлэлийн гишүүн бүр дээрх шаардлагуудыг хангасан байна.
<b>ТШЗ 18.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b> - Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого төсөвт өртгийн <b>80</b> хувиас багагүй байна.
<b>ТШЗ 18.2</b>	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: - Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа 2022, 2023 он - Харилцагч банкны мэдэгдэл - Монгол улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа

	<p>хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа</p> <p>- Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудад гаргасан санхүүгийн тайланг хавсарган ирүүлэх</p> <p>- Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд 2022, 2023 оны аудитын дүгнэлтийг хавсарган ирүүлэх ба ирүүлээгүй нь татгалзах үндэслэл болно</p>																																																												
<p><b>ТШЗ 19.1</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>1. Ажил гүйцэтгэх хүний нөөц: <b>“Шаардана”</b></p> <table border="1" data-bbox="435 499 1465 1789"> <thead> <tr> <th>д/д</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Туршлага</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер</td> <td>1</td> <td>3</td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td>Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер</td> <td>1</td> <td>3</td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td>Эргэх механизмийн инженер</td> <td>1</td> <td>3</td> <td></td> </tr> <tr> <td>4</td> <td>Өрлөг дулаалгын инженер</td> <td>1</td> <td>3</td> <td></td> </tr> <tr> <td>5</td> <td>Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин</td> <td>6</td> <td>5</td> <td></td> </tr> <tr> <td>6</td> <td>6-р зэрэгтэй, 2б-дээш категоритай гагнуурчин</td> <td>2</td> <td>5</td> <td></td> </tr> <tr> <td>7</td> <td>Категоритай болон хариуцлагатай металл хийцийн гагнуурчин</td> <td>2</td> <td>3</td> <td></td> </tr> <tr> <td>8</td> <td>ХАБЭА хариуцсан инженер</td> <td>1</td> <td>5</td> <td></td> </tr> <tr> <td>9</td> <td>Эргэх механизмийн 4-6-р зэрэгтэй засварчин</td> <td>4</td> <td>5</td> <td></td> </tr> <tr> <td>10</td> <td>Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5,6 зэрэгтэй ажилтан</td> <td>3</td> <td>5</td> <td></td> </tr> <tr> <td>11</td> <td>Оосорлогч дохиочин</td> <td>2</td> <td>5</td> <td></td> </tr> </tbody> </table> <p>- Маягтын дагуу гаргаж баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>- Дээрх хүмүүсийг оролцуулаад нийт ажиллах хүч 30-с доошгүй байх.</p> <p>- Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.</p> <p>- Дээрх инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх</p>	д/д	Албан тушаал	Хүний тоо	Туршлага	Мэргэжил	1	Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер	1	3		2	Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер	1	3		3	Эргэх механизмийн инженер	1	3		4	Өрлөг дулаалгын инженер	1	3		5	Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин	6	5		6	6-р зэрэгтэй, 2б-дээш категоритай гагнуурчин	2	5		7	Категоритай болон хариуцлагатай металл хийцийн гагнуурчин	2	3		8	ХАБЭА хариуцсан инженер	1	5		9	Эргэх механизмийн 4-6-р зэрэгтэй засварчин	4	5		10	Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5,6 зэрэгтэй ажилтан	3	5		11	Оосорлогч дохиочин	2	5	
д/д	Албан тушаал	Хүний тоо	Туршлага	Мэргэжил																																																									
1	Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер	1	3																																																										
2	Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер	1	3																																																										
3	Эргэх механизмийн инженер	1	3																																																										
4	Өрлөг дулаалгын инженер	1	3																																																										
5	Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин	6	5																																																										
6	6-р зэрэгтэй, 2б-дээш категоритай гагнуурчин	2	5																																																										
7	Категоритай болон хариуцлагатай металл хийцийн гагнуурчин	2	3																																																										
8	ХАБЭА хариуцсан инженер	1	5																																																										
9	Эргэх механизмийн 4-6-р зэрэгтэй засварчин	4	5																																																										
10	Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5,6 зэрэгтэй ажилтан	3	5																																																										
11	Оосорлогч дохиочин	2	5																																																										

шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай.

- Зарим инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, иргэний үнэмлэхийн хуулбарын хамт ирүүлнэ.
- Гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол дипломын хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.
- Мэргэжилтэй 10-с доошгүй ажилчдын жагсаалтыг мэргэжлийн үнэмлэхийн хуулбарын хамт ирүүлнэ.
- Дээрх инженер, техникийн ажилтнуудын 50-аас доошгүй хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар буюу 2022 оны 11, 12 дугаар сар 2023 оны 1 дүгээр саруудад тухайн компанийн нэр дээр төлсөн байх шаардлагатай.

Мэдээллийг төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй, цахим системд бүртгэгдсэнээс өөр мэдээлэл, нотлох баримтыг үнэлгээнд ашиглахгүй.

2. Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардана”**

д/д	Машин механизмын зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Улсын дугаар
1	Ачааны машин	1 тн-с дээш	1	
2	Хог ачих машин	5 тн-с дээш	1	

Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизмын гэрчилгээ, лавлагааг ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан шаардлагатай мэдээллийг шалгах ба цахим системд бүртгэгдсэнээс өөр мэдээлэл, нотлох баримтыг үнэлгээнд ашиглахгүй.

- **Ажлын материал, сэлбэг зөөх ачааны машинтай байх, (нотлох баримтыг хавсаргах)**
- **Хийцийн ажил гүйцэтгэх труба матагч, лист хуйлах, нугалах гэх мэт металл хийц бэлтгэх тоног төхөөрөмжтэй байх,**
- **380В-ын гагнуурын аппарат, металл огтлох, зүсэх төхөөрөмж 2-оос доошгүй комплект байх,**
- **Өнгөлгөөний гар машин, суурин таслагч, гар таль, оосорлох, татах татлага гэх мэт багаж уг ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх.**
- **Хэмжих, шалгах, турших багажууд**

3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: **“Шаардана”**

- Батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх
- Ижил төстэй ажил гэдэгт тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд хийсэн ажлыг хамааруулан үзнэ.



	<p>- Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар мэдээллийг V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэн ирүүлэх</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>- Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 5-ын дагуу ирүүлнэ.</p>
<b>ТШЗ 19.2</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажил гүйцэтгэсэн туршлагыг тооцоход 2022, 2023 онуудад гүйцэтгэсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актыг үндэслэл болгоно.</li> <li>- Гэрээ тус бүрийн ажлыг хэрхэн гүйцэтгэсэн талаар захиалагчийн тодорхойлолт ирүүлэх ба гүйцэтгэлийг үнэлгээнд харгалзан үзнэ.</li> <li>- Шалгарсан тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, харилцах мэдээллийг нэгтгэн ирүүлэх</li> <li>- Үнэлэгдсэн үе шатны хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>- Ажлын зураг, тоо хэмжээнд үндэслэн тооцсон төсөв зохиож, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулан ирүүлнэ. Төсөвт тусгагдах бүх зардлыг мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу тооцсон байна.</li> <li>- Ажилд ашиглагдах бараа материалын үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, гарал үүслийн мэдээллийг ирүүлэх</li> <li>- Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа талаар албан мэдээгдэл ирүүлэх</li> </ul>
<b>ТШЗ 19.3</b>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b></p> <p><b>ТЗ-3.3. 0,07-8,0 МПа / 0,7-80,0 гкх/см<sup>2</sup> / даралттай зуухны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ.</b></p> <p><b>ТЗ-8. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах</b></p> <p>Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй.</p>
<b>ТШЗ 21.6</b>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b></p>
<b>ТШЗ 24.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: <b>10,843,132.50 /арван сая найман зуун дөчин гурван мянга нэг зуун гучин хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөг байх ба гэрээ байгуулж 2 тал батлах хүртэл хүчинтэй байна.</b></p>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах нотлох баримт бичиг</li> <li>- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээний хамт</li> <li>- Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэлүүд</li> </ul>

	- Хуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй мэдээлэл баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл
<b>ТШЗ 26.1</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2024 оны 03-р сарын 11-ний өдөр</b> Цаг: <b>09 цаг 00 минут</b>
<b>ТШЗ 26.2</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>2024 оны 03-р сарын 11-ний өдөр</b> Цаг: <b>09 цаг 10 минут</b> Тендер нээх газрын хаяг: <i>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, "ДЦС-3" ТӨХК-ийн байр, 215 тоот өрөө.</i>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 31.1</b>	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <i>"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8-р зүйлийн 8.4-т заасан нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд тооцно.</i>
<b>ТШЗ 32.1</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>"Үгүй"</b>
<b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 37.1</b>	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>"Тийм"</b> <i>Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</i>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 38.1</b>	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>"Тийм"</b> <i>Урьдчилгаа төлбөр олгох хувь хэмжээ : Гэрээний үнийн дүнгийн 30 хувь</i> <i>Гэрээнд заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх ба эрх бүхий арилжааны банкаар гаргуулсан байна.</i>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### ДДС-ИЙН ЗУУХ №6-Д ХИЙГДЭХ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ДААЛГАВАР

##### ТЕХНИКИЙН ДААЛГАВАР:

##### 1. Ажлын нэршил:

“ДЦС-3” ТӨХК-н БКЗ-75-39фб маркийн зуухны дөлт шаталтын технологийг өөрчилж “Нам температурын хурдасгасан буцлах үет” шаталтын технологид шилжүүлэх төслийн ажил

##### 2. Ажлын төрөл:

“Техникийн тооцоо, зураг төсөл боловсруулж төсөв хийх, төслийн ажил гүйцэтгэх”

- Техникийн тооцоо /дулааны тооцоо, гидравлик тооцоо, аэродинамик тооцоо/
- Зураг, төсөв зохиох
- Угсралт, засварын ажил

##### 3. Объектийн хүчин чадал: Зуухны хүчин чадал. /хүснэгт/

№	Зуухны үзүүлэлтүүд	Даалгаварт зорилго	Одоо байгаа
1	Уурын боловсруулалт. т/цаг	75	63-67
2	Даралт , МПа ( кгс/см <sup>2</sup> )	3,9 (39)	3,9 (39)
3	Хурц уурын температур, °С	440	440
4	Тэжээлийн усны температур, °С	145	145
5	Утааны хийн температур, °С	130	162

##### 4. Ажлын агуулга:

Монгол Улсын Улаанбаатар хотын нүүрсээр ажилладаг, дулаан цахилгаан хослон үйлдвэрлэдэг “ДЦС-3” ТӨХК-ийн одоо ажиллаж байгаа БКЗ-75-39фб маркийн шууд үлээлгийн тоосон системтэй зуухны нүүрс шатаах технологийг өөрчилж “Нам температурын хурдасгасан буцлах үет” шаталтын технологид шилжүүлж уур боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын зураг, төсөл боловсруулж ДЦС-3 ТӨХК-ий техникийн комисст хянуулж, холбогдох мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийлгүүлсэн байна.

##### 5. Ажлын зорилго:

“ДЦС-3” ТӨХК-ийн БКЗ-75-39фб маркийн зуухны түлш шатаах технологийг өөрчилж, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээг хангахад шаардлагатай хэмжээний хурц уур боловсруулах, тасралтгүй, найдвартай ажиллах, байгаль орчинд ээлтэй, тооцоот чадлаа бүрэн авдаг зуухтай болох зорилготой.

##### 6. Тухайн ажилбаруудыг хийж гүйцэтгэхэд мөрдөх норм дүрэм, стандарт.

Техникийн зураг, төсөл боловсруулахад олон улсын болон Монгол улсын MNS стандарт, мөн эрчим хүчний тоног төхөөрөмж барилга байгууламжийн ТАД, ААД-ийг мөрдөнө.

## 7. ЗУРАГ, ТӨСӨВ ХИЙХ ОБЪЕКТИЙН МЭДЭЭЛЭЛ:

### Нүүрсний чанар

Үзүүлэлтүүд	Ажлын чийглэг, %	Ажлын үнслэг, %	Дэгдэмхий бодисын хэмжээ, %	Хүхрийн хэмжээ, %	Дулаан гаргах чадвар, ккал/кг
Багануурын уурхайн нүүрс техникийн шаардлага MNS 3818:2001” стандартын техникийн шаардлага	37,5	17,5	44,8	0,38	3360
“ДЦС-3” ТӨХК-д Багануурын уурхайгаас нийлүүлэгдсэн нүүрсний 2023 оны дундаж үзүүлэлт	34,2	9,6	43,0	0,26	3565

Нүүрсний төрөл	Битум А, %	Органик бодисын элементүүдийн найрлага, %					Гумины хүчлийн агуулга, %	
		C <sup>a</sup>	H <sup>a</sup>	C <sup>daf</sup>	H <sup>daf</sup>	(O+H+S) <sup>daf</sup>	HA <sup>a</sup>	HA <sup>daf</sup>
Хүрэн нүүрс Б2	5,2	62,40	4,6	72,5	4,75	5,71	14	15

Ордын нэр	Чийгийн агууламж (%)	Үнс	Дэгдэмхий	Хүхрийн	Дундаж илчлэг
		(%)	бодис(%)	(%)	
Багануур	34,2	9,6	43,0	0,26	3565

### Нүүрсний химийн найрлагын шинжилгээ

Нүүрсний уурхай	Шатамтгай бодис (хуурай, үнсгүй) (%)					Шатамтгай бодис (хүлээж авснаар)(%)				
	Нүүрс төрөгч	Ус төрөгч	Хүхэр	Хүчил төрөгч	Азот	Нүүрс төрөгч	Ус төрөгч	Хүхэр	Хүчил төрөгч	Азот
Багануур	72,5	4,75	0,38	5,71	0,91	62,4	4,6	0,38	5,71	0,91

## Үнсний бүрэлдэхүүний шинжилгээ

№	Нэр төрөл	Таних тэмдэг	Нэгж	Багануурын нүүрс
1	Цахиур	SiO <sub>2</sub>	%	57,4
2	Хөнгөнцагааны исэл	Al <sub>2</sub> O <sub>3</sub>	%	12,0
3	Төмрийн исэл	Fe <sub>2</sub> O <sub>3</sub>	%	5,5
4	Кальцийн исэл	CaO	%	11,2
5	Магнийн исэл	MgO	%	1,7
6	Натрын исэл	Na <sub>2</sub> O	%	0,5
7	Калийн исэл	K <sub>2</sub> O	%	1,8
8	Титанийн исэл	TiO <sub>2</sub>	%	0,6
9	Хүхрийн гуравч исэл	SO <sub>3</sub>	%	7,9
10	Манганы исэл	MnO	%	1,7

## ДЦС-3-д хэрэглэж байгаа түүхий усны үзүүлэлтүүд

### Зуухны усны шаардлага

№	Уур-усны ангилал	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	ДДС
1	Хэт халсан ба ханасан уур	Натри	мкг/дм <sup>3</sup>	<100
		Цахиур	мкг/дм <sup>3</sup>	нормчлохгүй
		РН		>7,5
2	Тэжээлийн ус	Хатуулаг	мкг-экв/дм <sup>3</sup>	<10
		Аммиак	мкг/дм <sup>3</sup>	<1000
		Цахиур	мкг/дм <sup>3</sup>	нормчлохгүй
		O <sub>2</sub>	мкг/дм <sup>3</sup>	<20
		CO <sub>2</sub>	мг/дм <sup>3</sup>	0
		Төмөр	мкг/дм <sup>3</sup>	<100
		Зэс	мкг/дм <sup>3</sup>	нормчлохгүй
		NO <sub>2</sub> +NO <sub>3</sub>	мкг/дм <sup>3</sup>	нормчлохгүй
		РН		8,5-9,5
		тослог	мг/дм <sup>3</sup>	<0,5
3	Турбины конденсат	Хатуулаг	мкг-экв/дм <sup>3</sup>	<10
		O <sub>2</sub>	мкг/дм <sup>3</sup>	<20
4	Тогооны ус /цэвэр хэсэг/	Фосфат	мг/дм <sup>3</sup>	2-6
		РН		>9,3
5	Ууршилтын шатлалгүй зууханд тогооны усны илүүдэл фосфат		мг/дм <sup>3</sup>	2-15
6	Тогооны ус /давстай хэсэг/	Фосфат	мг/дм <sup>3</sup>	<30
		РН		<11,8
		Харьцангуй шүлтлэг	%	<50
		Үргэлжийн үлээлэг	%	0,5-3

## ОРШИН БАЙГАА ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

Өргөрөг	47°53,48'54 N
Уртраг	106°51,59'04 E
Далайн түвшинээс	1290м
Хотоос ямар зайд	төвд
Нисэх буудлаас	9км
Төмөр зам	Төмөр замтай

### УУР АМЬСГАЛЫН МЭДЭЭЛЭЛ

Агаарын температур.

Технологийг хэрэгжүүлэх байршил нь дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй гадна агаарын жилийн дундаж температур -0,5...-2,6 0C байдаг бөгөөд хамгийн өндөр температур 7-р сард 35...40 0C, хамгийн бага температур 12...1-р сард -40,0...-49 0C хүрдэг.

Агаарын температурын сар, жилийн дундаж утга

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
"Буян-Ухаа" станц	-26.3	-23.1	-10.9	0.2	8.3	15.1	17.0	15.1	7.5	-2.1	-12.4	-24.0	-3.0
"Улаанбаатар" станц	-21.9	-18.4	-9.1	0.5	9.4	14.8	16.8	14.3	10.2	2.2	-12.5	-17.8	-1.2

### Хөрсний температур.

Газрын гадаргын өнгөн хөрсний дулааны горимоор агаарын доод үе давхаргын дулааны горим тодорхойлогддог. Улаанбаатар орчимд хөрсний гадаргын жилийн дундаж температур -0.1 °C, 1 -р сард -22°C, 7 -р сард 21 °C байдаг. Харин 1-р сард 48°C хүрч хүйтрэх, 7-р сард 61°C хүрч халах тохиолдол байдаг. Хөрсний температурын дундаж, үнэмлэхүй хамгийн их, бага утга

	Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
УБ	Дундаж	-24.6	-19.5	-7.7	2.9	13.4	18.9	20.6	18.0	10.4	0.3	-12.1	-21.5
	Tmax	10.0	23.5	35.2	48.0	58.6	60.7	61.4	60.0	52.0	36.9	17.0	5.5
	Tmin	-48.2	-43.0	-30.4	-22.5	-16.5	-6.0	9.5	7.4	-12.0	-21.0	-34.2	-35.9

### Агаарын чийгшил.

Улаанбаатар орчимд жилийн дундаж харьцангуй чийгшил 63-64% байна. Харьцангуй чийгшлийн сар, жилийн дундаж утгыг хүснэгтээр үзүүлэв.

Агаарын чийгшил

Сар, станц	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
"Буянт- Ухаа" станц	75	73	66	50	47	56	65	65	64	65	72	75	64

“Улаанбаатар”	71	67	56	49	53	62	67	66	63	61	65	72	63
---------------	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----

Газар нутгийн газар хөдлөлийн эрчимжилтийн байдал.

Тооцоот газар хөдлөлтийн эрчим - 8\*\*

Газар хөдлөлтийн үйлчлэлээр хөрсний зэрэглэл – II

Баллаар хэмжигдэх газар хөдлөлтийн аюул 7,8 балл

Тухайн газар нутагт 50 жилийн хугацаанд тооцоолсноос илүү хүчтэй газар хөдлөлт болох магадлал 10%

### Засгийн газрын зөвшөөрсөн хүхрийн давхар исэл, хөө тортогын нийт хэмжээний хяналтын үзүүлэлт

2011 онд шинээр боловсруулсан “Шинэ дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь зарим агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга” үндэсний стандард тусгагдсанаар:

**4.1. дэхь заалт** Шинээр барих **ДЦС**, дулааны станцын уурын ба ус халаах зуухнаас гарах утааны найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), хүхрийн давхар исэл (SO<sub>2</sub>), азотын ислүүд (NO<sub>x</sub>), дэгдэмхий үнсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ 1,2-р хүснэгтэнд заасан хязгаарт байна.

Нүүрсний дэгдэмхий бодис агуулалт	NO <sub>x</sub> , мг/м <sup>3</sup>
$V_{daf} < 10\%$	1100
$10\% < V_{daf} < 20\%$	650
$V_{daf} > 20\%$	450

#### 1-р хүснэгт - Азотын ислүүд (NO<sub>x</sub>)-ийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

#### 2-р хүснэгт - Дэгдэмхий үнс ба хүхрийн ислийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Муж	CO, мг/м <sup>3</sup>	SO <sub>2</sub> мг/м <sup>3</sup>	Дэгдэмхий үнс PM <sub>10</sub> , мг/м <sup>3</sup>
<b>I муж</b> (нэг км <sup>2</sup> талбайн хүн амын нягтрал 10хүн/ км <sup>2</sup> -аас дээш буюу 1000 хүн/ км <sup>2</sup> -аас бага байх хотын нутаг дэвсгэр)	180	400	50
<b>II муж</b> (нэг км <sup>2</sup> талбайн хүн амын нягтрал 10хүн/ км <sup>2</sup> -аас бага байх алслагдсан бүс нутагт)	300	600	200



## 9. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

### Техникийн зураг, төсөв хийх зуухны техникийн ерөнхий шаардлага

№	Агуулга	Тайлбар
1	Дотоод хэрэгцээний цахилгаан хэрэглээ нь харьцангуй буурсан байх шаардлагтай.	
2	Тоног төхөөрөмжийн байрлалын ерөнхий төлөвлөлтийг хийхдээ одоо байгаа зай талбайг оновчтой зохион байгуулах	
3	Байгаль орчинд ээлтэй, орчинд хаягдах хорт хийн агууламж Монгол улсын болон олон улсын стандарт хэмжээнээс ихгүй байх.	
4	Технологийн үйл ажиллагаанд хэрэглэж буй усны зарцуулалт одоогийн, түүнээс бага байх	
5	Зуух нь уур-усны ердийн эргэлттэй, нам температурын хурдасгасан буцлах давхаргын шаталтын технологитой, утааны хийн хорт агууламжуудыг эрс багасгасан байна.	
6	Зуухыг соляркаар галлах цогц системтэй байх	

### Өөрчлөлт хийсэн зуухны техникийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Нэгж	
1.	Уурын үйлдвэрлэх хэмжээ	Т/Ц	75 /хэвийн/
2.	Хурц уурын гарах даралт	МПа	3.9
3.	Хурц уурын гарах халуун	°С	440
4.	Тэжээлийн усны халуун	°С	145
5.	Агаар халаагчаас гарах хоёрдогч агаарын халуун	°С	240
6.	Утааны хийн халуун	°С	130
7.	Нүүрсний зарцуулалт	Т/Ц	16,8 ихгүй
9.	Зуухны А.Ү.К (бохироор)	%	90% багагүй

## Зуухны техникийн шаардлага

№	Агуулга	Тайлбар
1	Зуух нь 3.9 МПа, 440°С анхны параметрт ажиллахаар сонгогдсон	
2	Зуухны уур халаагч ба конвектив хэсгийн халах гадаргуунуудад /экономайзер, агаар халаагч /тооцооны үндсэн дээр тохируулга хийж зураг төсөл хийсэн байх.	
3	Зуухны зураг төслийг боловсруулахдаа өөрчлөлтийн хил хязгаарыг /түлшээр, анхдагч агаараар, хоёрдогч агаараар, утааны хийгээр/ нарийвчлан гаргасан байна.	
4	Зуухны шугам хоолой нь стандартын шаардлага хангасан гангаар хийгдсэн байна.	
5	Зуухны их бие, шугам хоолойн дулаалгын материал нь стандарт, ХАБЭА-н шаардлагыг хангасан байх.	
6	Галын хотлын элэгдэл ихтэй хэсгийг тусгай зориулалтын элэгдэлд болон галд тэсвэртэй бетоноор хамгаалсан байх	
7	Тооцооны дагуу туслах тоноглолуудын сонголтыг иж бүрдлээр нь оновчтой хийсэн байх	
8	Зуухны туслах тоног төхөөрөмжүүд нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ багатай, оновчтой байх	
9	Экран, экономайзерын халах гадаргуун дренажийн шугам хоолойн схемтэй байх	
10	Галлагаа хийх солярка, агаарын схемтэй байх	
11	Тоноглолын хөргөлтийн усны схемтэй байх	

### 10. Боловсруулах техникийн зураг, тооцоо, төсвийн баримт бичгийн бүрэлдэхүүн:

1. Даралтанд ажиллах хийцүүдийн холболт, зангилааны бат бөхийн тооцоо,
2. Дулааны ба аэродинамик, гидравликийн тооцооны үр дүнгүүд
3. Төслийн баримт бичгийн тайлбар, тэмдэглэл
4. Техникийн зурагт дараах үндсэн зорилгын зургууд боловсруулагдсан байна:
  - Өөрчлөлт хийсэн зуухны ерөнхий байдал бүх огтлолоор
  - Өөрчлөлт хийсэн хэсгийн ерөнхий байдал бүх огтлолоор
  - Өөрчлөлт хийх холболт зангилаануудын угсралтын зураг
  - Өөрчлөлт хийсэн хэсэг, шинээр хийгдэх тоног төхөөрөмжийн детальчилсан ажлын зураг
